



**НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Коронавирусын халдвараас сэргийлэх
ажлыг эрчимжүүлэх тухай

Сүүлийн үед Монгол улсын хэмжээнд зөвхөн Улаанбаатар хотод халдвартын тохиолдол бүртгэгдэж байна. 2021 оны 1-р сарын 11-нээс бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулснаас хойш шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо тогтвортой нэмэгдэж нэг халдвартай хүн цааш халдвартуулах хүний дундаж тоо 1.2 болж (өмнөх долоо хоногт $Re= 1$ (0.66 - 2) нэмэгдсэн, өсөлтийн хурд 6.1% байгаа нь нийслэлд халдвартын тоо цаашид нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.

Мөн манай улсын хэмжээнд бүртгэгдсэн Коронавируст халдварт (КОВИД-19)-ын өвчлөлийн 152 буюу нийт халдвартын 7.6% (өнгөрсөн долоо хоногт 8.2%)-ийг эрүүл мэндийн ажилтнуудын өвчлөл эзэлж байгаа ба үүнээс эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой халдварт 82%-ийг эзэлж байна.

Иймээс эрүүл мэндийн ажилчдыг халдвартын эрсдэлээс сэргийлэх, тусlamж үйлчилгээг халдварт хамгааллын тусгай дэглэмд үзүүлэх, тусlamж үйлчилгээний тасралтгүй, шуурхай байдлыг хангах, иргэдэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Харьяа байгууллагын дарга нарт:

1.1 Халдвартын батлагдсан тохиолдлын тоо, нэг халдвартай хүний цааш халдвартуулах дундаж тоо нэмэгдэж байгаагаас гадна халдвартын голомт, хавьтад дагасан “Нэг иргэн-нэг шинжилгээ” өргөтгөсөн шинжилгээг 2 дугаар сарын 11-ны өдрөөс хийж эхэлсэнтэй холбогдуулан тохиолдолын тоо ихсэх магадлалтай тул хэвтүүлэн эмчлэх орны болон хүний нөөцийн хувиарлалтыг шинэчлэн бэлэн байдлыг хангах,

1.2 Хэвтүүлэн эмчлэх ор бүхий эмнэлгүүд шинээр ирсэн өвчтөнийг эмчилгээний тасагт шилжүүлэхээс өмнө урьдчилан бэлтгэсэн тусгаарлан ажиглах түр тасагт хэвтүүлэн эмчилгээ оношлогоог шууд эхлэх, шинжилгээний хариуг хүлээх хугацаанд эмчилгээг таслахгүй байх, яаралтай ажилбар, хагалгаа, оношлогоог холбогдох тушаал, шийдвэр, заавар журмын дагуу халдварт хамгааллын өндөржүүлсэн дэглэм баримтлан үзүүлэх, коронавирусын халдвартай иргэдийг ХӨСҮТ ирж авталь түр байрлуулан эмчилгээ үйлчилгээг шуурхай үзүүлэх,

1.3 Шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо нэмэгдэх үед зөвхөн батлагдсан тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн, ойрын хавьтальг тусгаарлан ажиглах зөвлөмжийг мөрдэн эмчлэх тул коронавирусын халдвартын хөнгөн болон дунд зэргийн өвчлөлтэй

иргэдийн эмчилгээ, хяналтын талаар өрхийн эмч мэргэжилтэнүүдийг давтан сургах, арга зүйгээр хангах, үйл ажиллагаандаа зайн оношлогоо, цахим технологийг ашиглах,

1.4 Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт халдварт тархалт идэвхтэй байгаа тул өөрийн дүүрэг, нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, хүнс худалдааны зах, дэлгүүр зэрэг хүн ам олноор цугларч буй газруудад цэвэрлэгээ, халдвартгүйтгэл, агааржуулалт, агаар сэлгэлтийг сайтар хийх, хүн хоорондын зай барих, бүх хүн амны хаалттай байх, гарын ариун цэвэр сайтар сахих зэрэг иргэдэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлж өөрийн байгууллагын цахим хуудас, сошиал, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээллийг хүргэж сээрэмжлүүлэх. Мөн ковид халдвартын эрсдэлээс сэргийлэх амьдралын шинэ хэвийг нутагшуулахад санаачлагатай ажиллах,

1.5 Эмнэлзүйн хүнд болон маш хүнд тохиолдлууд нэмэгдэж байгаа нь нас барах эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байгаа тул эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, бэлэн байдлыг хангах, шаардлагатай тоног төхөөрөмжийн эмнэл зүйн ач холбогдолыг сайтар мэдээлж хангалах, хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх,

1.6 Эмнэлзүйн хүнд, маш хүнд тохиолдлууд нэмэгдэх хандлагатай байгаа нь эрүүл мэндийн ажилтан халдварт авах, өвчлөх эрсдэл улам бүр нэмэгдэж байгааг анхаарч халдвартын хяналт, сэргийлэлтийн дэглэмийг сайтар хэрэгжүүлэх, хяналтыг чангатгах. Ажилчдад үүсэх туйлдлын хам шинж (Syndrom Burn-out)-ээс сэргийлж тусламж үйлчилгээний багт ур чадвар дутах эрсдэл үүсгэлгүйгээр эрсдлээс сэргийлэх удирдлага хэрэгжүүлэх,

1.7 Эмнэлэг хооронд өвчтөн, сахиурыг шилжүүлэх, эмнэлзүйн эрэмбэлэн ангилалтанд сайн үр дүн авчрах халдварт хамгаалал, үйлчилгээ, хандлагын шинэ зохион байгуулалтыг хэрэгжүүлэх,

1.8 Эргэлтийн үйл ажиллагааг зөв зохицуулж, сахиур солихгүй байх, сахиуруудыг халдварт хамгааллын дэглэм сахих, бусад өрөө тасалгаагаар сэлгүүцэхгүй байхыг онцгойлон анхааруулах,

1.9 Эмнэлгийн ажилчдын тасаг нэгж хоорондын хөдөлгөөнийг хязгаарлах, хувцасны, үзлэгийн, албан өрөөнд халдварт хамгаалал, сийрэгжүүлэлт, зай барих, амны хаалтны хэрэглээг тогтмолжуулж, камерын хяналтыг хийж хадгалан сургалтад ашиглах, архивлах

Хоёр. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагч нарт:

2.1 Коронавиурсын халдварт өртсөн эмнэлгийн мэргэжилтэний 80-аас дээш хувь нь тусламж үйлчилгээтэй холбоотойгоор халдварт авсан байгаа тул халдвартын эрсдлээс өөрийгөө, гэр бүлээ болон мэргэжил нэгтнээ хамгаалах зорилгоор халдварт хамгааллын дэглэмийг ажлын байрандаа, гэртээ тогтмол, чанд мөрдөж ажиллах,

2.2 Халдварт авсан эмнэлгийн ажилтан бусдад халдвартараах эрсдэл өндөр тул хувийн гүйлтаар айл өрх, хувь хүнд тусламж үйлчилгээ үзүүлэхгүй байх, олон нийтийн газраар зорчихгүй байх,

2.3 Эрүүл мэндийн ажилтан нь нэг дор олон хүнд тусламж үйлчилгээ үзүүлдэг учраас ажлын байранд хувийн хамгаалах хэрэгслийг зохих стандарт, заавар, журмын дагуу тогтмол зөв хэрэглэх, зөв тайлах, зөв устгах, ажилбар бүрийн өмнө, дараа гар халдвартгүйтгэлийг байнга хийж хэвших,

2.4 Эрүүл мэндийн байгууллага нь халдвартын эрсдэл өндөртэй орчин тул гэр бүлээ эрсдэлээс сэргийлэн гадуур өмссөн хувцсаа гэртээ өмсөхгүй байх, ахуйн хэрэглээний зүйлсээ тусдаа байлгах, шаардлагатай бол амны хаалт зууж өөрийгөө тусгаарлах, халдвартгүйтгэл, агаар сэлгэлтийг тогтмол цагт хийх,

Дээрхи албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Эмнэлгийн тусlamжийн хэлтэст ирүүлнэ үү.

